



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/177

Арвайхээр

Зардал хуваарилах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.“б”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XIII.1.2.45 дугаартай Боловсролын салбарын их засвар /Өвөрхангай/ зарцуулах төсөл арга хэмжээний тухай Засгийн газрын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 15 дугаар тогтоол, 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/60 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боловсролын салбарын их засвар /Өвөрхангай/-д зарцуулах 700,000,000 (долоон зуун сая) төгрөгийн хөтөлбөр, арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтад тусгагдсан хөтөлбөр арга хэмжээг худалдан авах ажиллагааны хууль журмын дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (З.Балданням)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100336

Аймгийн Засаг даргын 2021 оны...⁰⁴
дугаар сарын 12...-ны өдрийн ...¹⁷...дүгээр
захирамжийн хавсралт



**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ТӨСВИЙН БАГЦАД
БАТЛАГДСАН ХИИ.1.2.45 ХУУЛИЙН ДУГААРТАЙ ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГАД ЭРХ ШИЛЖСЭН БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ИХ
ЗАСВАРЫН /ӨВӨРХАНГАЙ/ ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ**

№	Төсөл хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /төгрөг/
1	Богд сумын ЕБС-ийн хичээлийн байрны дотор цахилгааны засварын нэмэлт санхүүжилт	25,300,000
2	Хайрхандулаан сумын ЕБС-ын дотор усан хангамж, ариутгах татуургын шугам, тоноглол	80,000,000
3	Бүрд сумын ЕБС-ын их засвар	140,000,000
4	Есөнзүйл сумын СӨББ-ийн сантехник, агааржуулалтын засвар	74,000,000
5	Өлзийт сумын ЕБС-ийн дотуур байрын дээврийн их засвар	46,100,000
6	Арвайхээр сумын 4-р сургуулийн сантехникийн засвар	91,600,000
7	Арвайхээр сумын 5 дугаар цэцэрлэгийн ариутгах татуургын шугам сүлжээний засвар	30,000,000
8	Нарийнтээл сумын ЕБС-ийн Фасадын их засвар	115,000,000
9	Сумдын сургууль, цэцэрлэгийн дээврийн засвар	98,000,000
	НИЙТ ДҮН	700,000,000

-oOo-